Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анх дугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо,
А. Д. Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

18 дахь жилдээ №33 (1434) | 1965 оны 5 дугаар сарын 1 | БЯМБА

# Дэлхийн хөдөлмөрчдийн хаврын баяр

Анх 1886 оны 5 сарын 1-нд Америкийн Чикаго хотын үйлдвэрийн ажилчдын 8 цагийн ажлын өдрийг тогтоохоор улс төрийн сүрт жагсаал хийсэн түүхт өдрийг 2 дугаар интернационалын их хурлаас хожим нь орон бүрийн пролетари нарын баярын өдөр болгохоор тогтоожээ.

Дэлхийн орон бүрийн пролетари нарын баярын энэ өдрийг дэлхий дахины ажилчин анги 1890 оноос эхлэн жил бүр тэмдэглэж олон улсын ажилчин анги, хөдөлмөрчдийн эв санааны нэгдэл, ах дүүгийн барилдааг улам нягтруулсаар ирлээ.

Дэлхийн орон бүрийн ажилчин анги хаврын энэ баяраа 76 дахь удаагаа тэмдэглэхдээ империалист колоничлолын эсрэг хувьсгалт тэмцлээ улам хүчтэй болгож бүх дэлхийг чөлөөлөх, хэрэгтээ гайхамшигт сайхан амжилт олж тэмцлийнхээ цаашдын зорилтыг тодорхойлж байна.

Дэлхийн ажилчин ангийн ба эрх чөлөөний хөдөлгөөнд социалист системийн орнуудын ололт амжилтууд нь зоригжуулагч жишээ болсоор байна.

Дэлхийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд социалист орнуудын бүтээгдэхүүн 40 гаруй хувийг эзлэх болов.

Социализм нь Ази, Европоор хязгаарлахгүй, бөмбөрцөгийн нөгөө тал—Америк тивд Кубын баатарлаг ард түмэн социализмыг байгуулж байна.

Социалист системийн орнуудын хөгжил цэцэглэлт нь Ази, Африк, Латин Америкийн ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнд шийдвэрлэгч нөлөө үзүүлж империалист колоничлолд үхлийн цохилт болж байна.

Сүүлийн 17 жилд 1,5 миллиард хүн бүхий колони, хагас колони орнууд тусгаар тогтнолоо оллоо. Зөвхөн өнгөрөгч 1964 онд Малави, Мальт, Замби энэ онд баруун Африкийн Гамби улсуудад эрх чөлөөний наран гийж тусгаар тогтнолоо олсон билээ.

Дэлхийн ажилчин анги, хөдөлмөрчдийн манлайд коммунист ба ажилчны намууд байгаа бөгөөд одоо эгнээндээ 40 гаруй сая коммунистуудыг багтаасан 90 гаруй коммунист ба ажилчны нам ажиллаж байгаа ажээ.

Дэлхийн ажилчин, хөдөлмөрчдийн интернационалч нэгдэл, хувьсгалт хөдөлгөөний өрнөлтийн зэрэгцээгээр империализмын сүйрэл нь улам бүр хурцдаж мөхөлөө ойртуулсаар байна.

Тэд НАТО-гийн олон этгээдийн цөмийн нэгдсэн хүчин, атомын бөслүүр ба «поларис» пуужин бүхий шумбадаг онгоцны байрлал байгуулахыг оролдож зэвсэглэлээр хөөцөлдөх, дэлхийн янз бүрийн хэсэгт түрэмгий үйлдлээ үргэлжлүүлсээр БНА Вьетнам улсын эсрэг түрэмгийлэх халдлагаа зогсоохгүй байна.

Империалистуудийн эсрэг дэвшилт бүх хүчин нэгдэж тэмцэж байгаа ба түүнийг ажилчин анги манлайлах ёстой.

Саяхан Москвад болж өнгөрсөн коммунист, ажилчны намуудын төлөөлөгчдийн зөвлөлдөх уулзалт бол орчин үеийн бүх хувьсгалт хүчийг нийтийн дайсны эсрэг тэмцэлд нягтруулахад маш чухал алхам боллоо.

Энэ зөвлөлдөх уулзалтын албан мэдээнд заахдаа «... империализмийн эсрэг амжилттай тэмцэхийн тулд социалист хамтын нөхөрлөл, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, олон улсын ажилчин анги зэрэг орчин үеийн хувьсгалт бүх хүчийг нягтруулах явдал шийдвэрлэх ач холбогдолтой юм» гэжээ.

Энэ зорилтыг хангахын үүднээс дэлхийн коммунист хөдөлгөөний нэгдлийг улам нягтруулах нь эрхэм чухал зүйл мөн.

Манай ард түмэн намынхаа жолоодлогоор их Лениний сургаалаар капитализмыг алгасаж социализмыг амжилттай байгуулж, Ази, Африк, Латин Америкийн ард түмэнд сайхан жишээ болж байна.

Манай аймгийн хөдөлмөрчид бүх ард түмнийхээ хамт хаврын их баяраа ажлын өрнүүн амжилтаар угтаж малын төлийг сайн бойжуулж хаврын тариалалт, хялгас, хөөвөр, ноолуурын төлөвлөгөөг амжилттай биелүүлж байна.

Манай ард түмэн Майн нэгний баяраа өргөн тэмдэглэхийн хамт 1965 оны зорилтууд, МАХН-ын Төв Хорооны 6 дугаар бүгд хурлын шийдвэрийг амжилттай биелүүлж хөдөлмөрийн өрнүүн их бүтээлээр орон нутгийн сонгуулийг угтах зориг төгөлдөр ажиллаж байна.




## ТЭРГҮҮНИЙ АГЕНТ

Баяндэлгэр сумын 2 дугаар бригадын Дамдинсүрэн гуай 20 жил худалдаа бэлтгэлийн агентаар ажиллаж худалдааны ажилд дадлага туршлагатай болсон тэргүүний хүн.

Дамдинсүрэн гуай амьдралынхаа удаан хугацаанд агент хийхдээ хөдөлмөрчдийг худалдаагаар шуурхай сайн үйлчилж, улсын бэлтгэлийн төлөвлөгөөг нэр төрөл дээр нь давуулан биелүүлэхийн төлөө хүч чармайлтаа гарган ажилладаг юм.

Дамдинсүрэн гуай худалдагч, нярав, нягтлан бодох зэрэг 3—4 мэргэжилтэй болжээ.

Дамдинсүрэн хөдөлмөрчин олны эрэлт хүсэлтийг анхааралтай хүлээн авч, хүссэн бараагий нь захиалж эзэнд нь авчирч өгдөгөөс гадна өөрийн хариуцсан 60 гаруй өрхөөр 7 хоногт нэг удаа явж худалдаа хийхийн хамт бэлтгэлийн зүйлийг цуглуулан авдаг.

Ингэж ажилладаг учраас 17 жил бараа гүйлгээний төлөвлөгөөг 1,6—42,3 хувь давуулж 18 жил бэлтгэлийн төлөвлөгөөг нэр төрөл дээр нь биелүүлж, хөлдүү түүхий эд, арьс шир, ангийн үсний чанарыг дээшлүүлж дахин боловсруулалт хийснээс 8000 төгрөгийн ашиг улсад оруулжээ.

Дамдинсүрэн гуай энэ оны нэгдүгээр улирлын бараа гүйлгээний төлөвлөгөөг 103,2 хувь, бэлтгэлийн 25 нэр төрлийн зүйлийг 4,3—65 хувиар давуулж гялалзсан амжилт гаргав. Майн нэгний 76 жил, ардын хувьсгалын 44 жилийн ойг угтаж Мөнгөн морьтын агент Төмөрмөнхийн туршлагаар явуулын худалдааны тэрэг хийх, эхний хагас жилийн худалдаа бэлтгэлийн төлөвлөгөөг нэр төрөл дээр нь давуулан биелүүлэх нэмэлт үүрэг аваад зориг бадрангуй ажиллав.

*Д. Дондогдорж*

## ЗӨВЛӨЛГӨӨН БОЛОВ

Аймгийн санхүү бүртгэлийн ажилчдын зөвлөлгөөн аймгийн төвд дөрөвдүгээр сарын 28—29 нд болов. „Санхүү бүртгэлийн ажлын одоогийн байдал цаашдын зорилт" гэсэн илтгэлийг Аймгийн гүйцэтгэх захиргааны төлөвлөгөө эрхэлсэн орлогч дарга Дондогдорж тавив. Зөвлөлгөөнд аймгийн 13 дугаар авто баазын ерөнхий нябо Дагва, Хүнсний комбинатын Вандуй нарын зэрэг 23 хүн үг хэлэв.

Зөвлөлгөөний ажиллагааны явц тавигдаж байгаа зорилтын талаар Аймгийн гүйцэтгэх захиргааны дарга Жамсран дэлгэрэнгүй үг хэлэв.

# Социалист хууль ёсыг ширхэгчлэн биелүүлье

## *Хуульчдын зөвлөлгөөний өмнө*

Тус аймгийн хуулийн байгууллагууд улсын хэмжээний хуулийн удирдах ажилтны зөвлөлгөөнийг угтаж 3 сарын ажлын төлөвлөгөө зохиож, аймгийн шүүх нүүдлийн шүүхийн шүүгчдийн харъяаллаар ардын төлөөлөгчдийн 24 зөвлөл, 90 хэсэг, 82 секцийг тус тус зохион байгуулж 30 шахам удаа 446 ардын төлөөлөгчдөд, олон нийтийн шүүхийн дарга, гишүүдэд 20 удаа ажил төрлийн семинар зөвлөлгөө өгчээ.

Мөн цагдан сэргийлэхэд туслах бригадын гишүүдийн семинар зөвлөлгөөн хийж уриалга гарган ажиллаж байна.

Аймгийн төв хөдөөд хөдөлмөрийн үзлэг явуулж тодорхой ажилгүй 300 шахам хүнийг нэгдлийн үйлдвэрлэлд ажиллуулла.

Хуулийн байгууллагууд хамтран аймгийн хэмжээгээр сүүлийн 5 жилд гарсан гэмт хэргийн шалтгааныг судлан дүгнэлт хийж хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх явдлыг хүчтэй болгох зорилгоор илтгэл боловсруулан төв орон нутагт бүх байгууллагуудын хурлаар хэлэлцүүллээ.

Бүх байгууллага, сум—нэгдэл, САА—нуудыг хуулийн гурван байгууллагын төлөөлөгчид хуваарлин хариуцаж тодорхой судлагаа хийж өмч хөрөнгийн хамгаалалт өр авлагыг гардан шийдвэрлэж байна.

Архустын САА—н төвд гэмт хэрэг гарах явдал нилээд байсанд дүгнэлт хийж, хамт олны хурлаар хэлэлцүүлж, зарим хэргийг газар дээр нь шийдвэрлэсэн нь үр дүнгээ өгч байна.

Мөн шүүх, прокурор, цагдан сэргийлэх байгууллагууд хамтран хэрэг зөрчилд орж болзошгүй 62 хүнийг бүртгэн зөвлөлгөөн өгсөн, удаа дараа хуулийн хариуцлага хүлээж байсан Сэргэлэн сумын харъяат, одоо хоньчноор ажиллаж байгаа Индрээгийн одоогийн байдлыг фото зургаар харуулж засарч хүмүүжсэн тухайн яриаг нь соронзон хальсанд бичин авч сурталчилж байна. Аймгийн төвийн албан байгууллагуудын нууц хадгалалтын байдал, гал командын хэрэглэл, жижүүр манааны харнуцлагыг сайжруулах тухай зөвлөлгөөн хийлгэжээ.

Мөн хуулийн байгууллагууд хамтарч Гачуурт, Эрдэнэсант, Угтаал, Борнуур, Батсүмбэр, Жаргалант зэрэг сум хороодод хууль дүрэм сурталчлах бригад ажиллаж 6000 гаруй хүнд танилуулгын ажил зохиожээ.

Цаашид хуулийн байгууллагын удирдах ажилтнуудын зөвлөлгөөнийг угтаж нилээд зүйлүүд хийж байна.

*Д. Аюурзана*

## *Хэрэг бүртгэх байгууллага*

Хэрэг бүртгэх байгууллага нь гэмт хэрэг ба түүнийг үйлдсэн этгээдийг олж илрүүлэхийн тулд зайлшгүй шаардлагатай шуурхай эрэн сурвалжлах ба эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан бусад арга хэмжээг авах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба түүнийг таслан зогсоох шаардлагатай бүх арга хэмжээг авах үүрэгтэй байгууллага юм.

Хэрэг, хэрэг бүртгэх байгууллагад ямарч хэлбэрээр мэдэгдэж болох юм. Жишээ нь: Ард иргэдийн өргөдөл гомдол, албан газрын мэдээлэл, олон нийтийн шүүхийн тогтоол, хэвлэлд нийтлэгдсэн мэдээ материал, насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комиссын тогтоол, хэрэг үйлдэгч хэргээ өөрөө илчилсэн бусад мэдээ өөрсдийн санаачлага зэргээр үүсэн илрэх болно.

Хэрэг бүртгэгч хүн ямарч хэргийн талаар хэрэг бүртгэх анхны ажиллагааг хийх үүрэгтэй.

Хөдөө сумдыг харъяалан суугаа хэсгийн төлөөлөгч, авто техникийн байцаагч зэрэг хүмүүс энэхүү ажиллагааг гүйцэтгэж байна. Харин хэрэгт урьдчилсан мөрдөн байцаах ажиллагааг сэргийлэхийн ба прокурорын мөрдөн байцаагч нар явуулна.

Хэрэг бүртгэх ажиллагаа, урьдчилсан мөрдөн байцаалт хоёрыг хутган ойлгож болохгүй.

Энэ хоёр бол салшгүй холбоотой нэг юмны хоёр шат юм.

Шүүх, прокурор, цагдан сэргийлэх байгууллагын хэний харьяалалтыг харгалзахгүй хүлээн авч хэрэг бүртгэх ажиллагааг цагдан сэргийлэх байгууллагад явуулах үүрэгтэй.

Харин прокурор бол хэний ч харъяалалын хэрэг байсан түүнд хэрэг бүртгэх ба мөрдөн байцаах ажиллагааг явуулах бүрэн эрхтэй юм. Үүнээс үзвэл хөдөө сумдад сууж байгаа төлөөлөгч, цагдан сэргийлэх хэлтэс ба шууд прокурорын алины нь харъяаллын хэргийг хүлээн авч бүртгэх ба энэ ажиллагааг 14 хоногийн дотор хийх үүрэгтэй.

Хэрэг бүртгэгч хэсгийн төлөөлөгч хэрэг бүртгэх ажиллагаагаа гүйцэтгэхийн тулд үзлэг хийх, зарим зүйлийг хураан авах, сэжигтэй хүмүүсийг албадан саатуулах, хохирогч ба гэрчийг нь байцаах зэрэг ажиллагааг хийх эрхтэй. Хэрэг бүртгэх байгууллагын бүртгэх ажиллагаа хууль зүйд нийцэж байгаа эсэхийг прокурор хяналт тавьж байх ёстой.

Иймд гэмт хэргийн улмаас сэтгэл санаа, эд материал, мах бодийн хувьд гэмтэл, хохирол хүлээсэн хүн ба албан байгууллага өөрийн гомдлыг ам ба бичгээр шууд мэдэгдэх эрхтэй ба хэрэг бүртгэгч нар түүнийг хүлээн авч барагдуулах үүрэгтэй юм.

*О. Дорж*

## ХУУЛИЙН УХУУЛГА

*** Аймгийн намын хорооны хууль сурталчлах ба хуулийн зөвлөлгөө өгөх бригадынхан Жаргалантын сангийн аж ахуйн төв, хөдөөд 3 өдөр ажиллаж олон газар яриа лекц хийж, үзүүлэн танилуулах материал өргөн ашиглаж эрүү ба иргэний болон гэр бүл нийгмийн хэв журмын холбогдолтой хууль дүрэм, зарлиг тогтоолоос мянга гаруй хүнд тайлбарласан байна.

Ялангуяа хууль дүрэм зөрчиж, гэмт хэрэг гарч буй шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой тайлбарласан байна.

*Т. Банзрагч*

*** Төв орон нутгийн хуулийн байгууллагын удирдах ажилтны улсын зөвлөлгөөнийг угтаж гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах тухай аймгийн намын хорооны тогтоолын заалтыг биелүүлэхийн тулд Заамар сумын намын үүрийн товчоо хурлаараа хэлэлцэж 3 сарын ажлын төлөвлөгөө зохион хөдөлмөрчдийн дунд хууль дүрэм сурталчлах ажил зохиож байна.

„Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд иргэн бүр идэвхитэй оролцоё" гэсэн сэдвээр тус сумын бригад, фермд, хөдөлмөрчдийн гэгээрлийн хурлууд болж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай лекц яриа хийв.

Тариа бригадын дарга Аюуш, үхрийн фермийн суурийн ахлагч Лувсанбалдан, Лувсанзэгвэ, худалдаа бэлтгэлийн ангийн ня—бо Базар нарын зэрэг хүмүүс өөрсдийн хариуцсан суурь, бригадаа гэмт хэрэггүй бригад, суурь болгох үүрэг аваад ажиллаж байна.

*Т. Мушаа*

# ХУУЛЬ ЁСЫГ БИЕЛҮҮЛЭХЭД ТӨРИЙН ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮҮРЭГ

Социалист хууль дүрмийн жинхэнэ биелэл нь үйлдвэрлэлийн салбар бүрт үйлчилж биелэлээ олж амьдрал практикийн асуудлаар баяжин хөгжиж байдаг.

Чухам ийм учраас тус улсын хууль ёсыг биелүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагууд онцгой үүрэгтэй юм.

Тус аймгийн Баянцагаан, Баянжаргалан, Баян, Өндөрширээт, Батсүмбэр, Угтаал, Заамар, Их Хайрханы уурхай зэрэг газруудын төрийн захиргааны байгууллагууд хуулийн сурталчилгаа нэвтрүүлгийн ажлыг сар улирал дутамд сайн зохиодог ба хууль дүрмийг биелүүлэхийн тулд өөрт өө байгаа эрхийг бүрэн ашиглаж сайн ажиллаж байна.

Манай аймгийн нийт сумд ба албан байгууллага бүр аймгийн намын хорооны тогтоолыг биелүүлэх үндсэн дээр төв хөдөөгийн хуулийн байгууллагуудын удирдах ажилтнуудын улсын зөвлөлгөөнийг угтаж хууль дүрэм сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хуучин өр авлагыг хурааж дуусгах ажил зохиож энэ талаар нилээд ахицтай ажиллаж байна.

Төрийн орон нутгийн байгууллагууд хууль дүрмийг сурталчлах, ухуулах түүний биелэлтэнд хяналт тавих эрхээ бүрэн эдлэхгүй зарим үед шаардагдах хууль дүрмийг шүүрч авч сурталчилсан болдгоор ажлаа хязгаарлах явдал бас л байна.

Ийм газар гэмт хэрэг гарч ирэх ба албан байгууллагын эрх зөрчигдөх явдал олонтой үзэгддэг байна.

Ийм байдал тус аймгийн Эрдэнэсант, Дэлгэрхаан, Эрдэнэ, Архуст, Борнуур, Жаргалант, Баянцогт суманд гарч байв.

Улс аймгийн ба сумын төлөвлөгөөнүүд түүнийг биелүүлэхэд чиглэгдсэн тодорхой заалт бүхий хууль дүрэм тогтоолуудыг хөдөлмөрчдөд хэдий чинээ сайн ойлгуулан итгүүлж чадваас тэнд үйлдвэрлэлийн явц хурдасч хөдөлмөрийн бүтээл өндөржиж, төлөвлөгөөт ажлууд хугацаандаа биелэгдэж байдаг байна.

Үүнийг тус аймгийн тэргүүний сумдын ажиллагаа баталж байгаа юм. Нөгөө талаар төрийн захиргааны байгууллагуудаас хууль ёсыг ширхэгчлэн биелүүлэх ажилд олон нийтийн орон тооны ба орон тооны бус байгууллагууд тусалдаг байх ёстой.

Эдгээр байгууллагууд хууль ёсыг сурталчлан танилуулах ажлыг голлон хийвэл зохих бөгөөд мөн хүмүүсийн хүчийг зохион байгуулах ажилд идэвхитэй оролцох ёстой юм. Цаашилбал хууль зүйн биелэлтэнд олон нийтийн хяналтыг хүчтэй тавьж дутагдлыг хамт олноороо хэлэлцүүлэн засуулах буюу зохих байгууллагад нь мэдэгдэж зүй ёсны арга хэмжээ авахуулах ёстой байна.

Үйлдвэр, аж ахуйн газрууд, албан байгууллага бүхэн өөрийн байгууллага дээр зохиох ажилдаа хууль ёсыг хатуу биелүүлж хууль дүрмийн сурталчилгаа нэвтрүүлгийн ажлыг хүчтэй зохиож байгууллага нь ажилчнаа хүмүүжүүлэх хүндтэй зарчимыг хатуу баримтлан ажиллавал зохино.

Эдгээр ажлыг гагцхүү орон нутгийн төрийн байгууллагууд удирдан ажиллах ёстой.

Энэ бүхний нийлбэр дүн нь эцсийн эцэст манай улсын социализмын байгуулалтыг хурдасгаж хүмүүсийн харьцаанд коммунист хүмүүжлийг баттай тогтоож чадна.

*Ж. Мөнхтогоо*

*(Аймгийн шүүхийн дарга)*